

“Монголын Давос”



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК



**ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АНХДУГААР ЧУУЛГАН:
“ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН СОРИЛТ, ЧИГ ХАНДЛАГА**

ХУРЛЫН ТОВЧООН: 2018 оны 1 дүгээр сарын 19-20-ны өдөр





“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК



**ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АНХДУГААР ЧУУЛГАН:
ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН СОРИЛТ, ЧИГ ХАНДЛАГА**

ХУРЛЫН ТОВЧООН: 2018 оны 1 дүгээр сарын 19-20-ны өдөр

АГУУЛГА

| | |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| Нээлтийн үг - Н.Баяртсайхан, Монголбанкны Ерөнхийлөгч..... | iii |
| Нээлтийн үг - Д.Дамба-Очир, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга..... | iv |
| Нээлтийн үг - Б.Чойжилсүрэн, УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга..... | v |
| Хуралдаан 1 - Мөнгөний бодлогын хэрэгжилт, сургамж..... | 1 |
| Хуралдаан 2 - 2018 оны эдийн засаг, санхүүгийн сорилтууд..... | 4 |
| Хуралдаан 3 - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, крипто валют, цахим мөнгө: Бидний байр суурь..... | 9 |



Нээлтийн үг

Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье! Бидний урилгыг хүлээн авч хүрэлцэн ирсэн УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга, Төсвийн байнгын хорооны дарга, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний статистикийн хорооны дарга болон Монголын санхүүгийн зах зээлийн гол зохицуулагч, оролцогч байгууллагуудын төлөөлөл, эрхэм зочид төлөөлөгч Та бүхэндээ Монголбанкны нэрийн өмнөөс талархлаа илэрхийлье!

Шинэ оны эхэнд бид ажил хэрэгчээр ийнхүү уулзаж байгаа нь улс орныхоо эдийн засаг, санхүүгийн секторт шийдвэрлэх асуудлуудаа ярилцах, нэгдсэн гарц гаргалгаанд хүрэх үнэтэй боломжийг бүрдүүлнэ гэж найдаж байна. Өнгөрсөн 2017 он бол Та бидний хувьд эдийн засгаа тогтворжуулж чадсан маш чухал жил байлаа. Амаргүй ч жил байсан. Дефолт, ханшийн огцом савлагаа, санхүүгийн системийн хямрал, эдийн засгийн уналт, магадгүй үүнийг даган нийгмийн тогтворгүй байдалд ч хүрч болох аюултай нүүр тулахад ойрхон байв. Дахиж ийм сорилт, ийм хүнд үетэй Монгол орон бүү тулгараасай!

Та бид хамтын зүтгэлээр саад бэрхшээлийг давж гарч чадсан. Өнөөдөр төлбөрийн тэнцэл, валютын нөөц, богино хугацааны өрийн дарамт, зээлжих зэрэглэл, өсөлт гээд эдийн засгийн олон үзүүлэлт дээр эерэг хандлагууд ажиглагдаж, зах зээл дээрх итгэл сэргэж эхлээд байгааг бид бүхэн харж байна. Энэ бол Та бидний хөдөлмөрийн, зүтгэлийн үр дүн юм. Эдийн засагт тулгарсан аюул, эрсдэлүүд биднээс түр холдсон ч цаашид хийх ажил нөр их байна. 2018 он бидний хувьд бий болсон эерэг өөрчлөлтөө бататгаж, ирээдүйн тогтвортой хөгжлийн суурийг бүрдүүлэх маш чухал жил юм. Макро түвшний таатай өөрчлөлтүүдийн үр өгөөж нийгмийн өргөн хүрээнд мэдрэгдэхийн тулд энэ жил юу хийж хэрэгжүүлэх вэ гэдэг шийдвэрлэх нөлөөтэй байх болно. Хямрал хүндрэлээс аливаа улс орон сургамж авч, алдаа дутагдлаа засаж залруулах ёстой. Манай улсын хувьд 2009 онд тулгарсан хямралын үед хийсэн шинэчлэл өөрчлөлтүүдээ тууштай хэрэгжүүлэх, бүрэн ажил хэрэг болгох зүтгэл дутсанаас өнөөгийн хүндрэл үүссэн юм. Бидний даван туулахыг зорьж буй эдийн засгийн энэ хүндрэл бол цар хүрээний хувьд, үргэлжилсэн хугацааны хувьд 90-ээд оны хүнд хэцүү жилүүдээс хойш тулгарсан хамгийн том сорилт болж байна.

Хэдийгээр одоо бид ангал руу унах аюулаас аврагдсан ч, хавцлын ирмэг дээрээс тийм ч холдоогүй байна. 2017 он бол олон улс орны хувьд дэлхийн эдийн засгийн хямралаас хойшхи 10 жилд тохиосон хамгийн таатай жил болсон. Сэргэлт 2018 онд ч үргэлжилж, дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал сайжрах төсөөлөлтэй байна. Нэг талаар бидэнд ийнхүү аз тохиосон ч, хөдөлмөр зүтгэлийг аз ивээдэг юм. 2018 онд зээлжих зэрэглэлээ өсгөх, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх тогтолцоогоо сайжруулан “саарал жагсаалт”-д орох эрсдэлээс гарах, өрийн дарамтаа бууруулах, валютын нөөцөө үргэлжлүүлэн нэмэгдүүлэх зэрэг тодорхой зорилгууд, сорилтууд бидний өмнө бий. Өөрчлөлт шинэчлэлт, эдийн засгийн эмчилгээ өөрөө амаргүй зүйл. Үргэлж амттай сайхан байх ч албагүй бөгөөд, гашуун хэдий ч уух ёстой эм мэт байдаг. Энэ үед мэдээллийн дутмаг, хомс байдал нь нийгэмд буруу ойлголт төрүүлэх, зүй бус няцаалт шүүмжлэлүүд газар авах, улс төрийн болоод бусад зорилготой дайралтууд идэвхжих нөхцөлийг бүрдүүлдэг. Улмаар сайн бодлого хэрэгжихгүй байх, хэрэгжихэд саад учрах өндөр эрсдэлүүдийг бий болгож байна.

Иймд бид хийсэн ажлаа, хийж буй зүйлээ, тэдгээрийн үндэслэл шалтгаан, зорилгоо идэвхтэй түгээх, үнэн зөвөөр тайлбарлаж ойлгуулах шаардлага зүй ёсоор урган гарч ирж байгаа юм.

Н.Баяртсайхан

Монголбанкны Еранхийлөгч



УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хорооны мэндчилгээ



Энэхүү чуулганд хүрэлцэн ирсэн хүндэт зочид, төлөөлөгчид Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая!

Шинэ оны босгон дээр эдийн засгийн төлөв байдал, тухайн цаг үед болон ойрын ирээдүйд эдийн засагт тулгамдаж буй сорилт, асуудлуудыг хамтран хэлэлцэж, шийдэл хайх эдийн засгийн бодлогын чуулганыг жил бүр уламжлан болгон зохион байгуулж байгааг чухал санал, санаачлага гэж үзэж байна.

Сүүлийн жил гаруй хугацаанд эдийн засгийг тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд нааштай үр дүнгүүд эхнээсээ гарч эхэллээ. Эдийн засгийн өсөлт 5-аас дээш хувийн өсөлттэй, гадаад валютын нөөц 3 тэрбум ам.долларт хүрсэн, улсын нэгдсэн төсвийн орлого 8.2 хувиар давж биелсэн, инфляци зорилтот 8 хувийн түвшнээс бага зэрэг эдийн засгийн бодлогын хүрээнд тавьсан зорилтуудаа бүрэн хангаж шинэ оны босготой золголоо. Гэхдээ эдгээр эерэг үр дүнгүүдээ баталгаажуулах, улмаар дунд урт хугацаанд тогтвортой байлгах үндэс суурийг бүрдүүлэх том сорилт бидний өмнө хэвээр байна.

Энэхүү анхдугаар чуулганыг “Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд” гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд зохион байгуулж байгаа нь цаг үеэ олсон чухал сэдэв гэж үзэж байна. Ялангуяа, өнгөрсөн хэрэгжүүлсэн бодлогын үр дүн, сургамжаа дүгнэж, ирэх оны төлөв байдлаа ярилцаж, тулгарч буй сорилт бэрхшээлээ хэрхэн шийдвэрлэх талаар хамтран хэлэлцэж байгаа туйлын чухал байна.

Эдийн засгийн байнгын хорооны даргын хувьд, Монгол улсын эдийн засгийн бодлогыг нэгтгэх үүрэгтэй байгууллагыг тэргүүлж байгаагийн хувьд энэ бол бидний жил бүрийн Давос болно гэж би хэлэх байна. Тийм учраас энэхүү хурлын арга хэмжээг цаашид уламжлал болгон зохион байгуулж байгаасай гэдгийн Монголбанкны удирдлагуудад энэ индрээс захиж хэлэхийн ялдамд бас талархал илэрхийлэхийг хүсч байна.

Ингээд Та бүхний өнөөдрийн хэлэлцүүлэгт амжилт хүсэхийн ялдамд Монгол Улсын орон сууцны зээлийн санхүүжилтийг боловсронгуй болгох, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чухал үр дүн, санал санаачлага гарна гэдэгт гүнээ итгэж байгаагаа уламжилъя.

Анхаарал тавьсанд баярлалаа!

Д.Дамба-Очир

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны дарга

УИХ-ын Төсвийн байнгын хорооны мэндчилгээ

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө, Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулганд оролцохоор хуран цугларсан Та бүхэнд чин сэтгэлийн халуун мэндийг хүргэе. Энэхүү чуулганыг санаачилсан Монголбанк, хамтран зохион байгуулж байгаа Эрдэнэт үйлдвэр, Улаанбаатар Төмөр Зам Хамтын Нөхөрлөлийн Нийгэмлэг болон чуулганы үйл ажиллагаанд оролцож буй Та бүхэнд талархал илэрхийлье.

Өнөөдөр эдийн засгийн салбарын чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн судлаачид, төрийн байгууллагуудын төлөөллийг цуглуулж “Эдийн засгийн бодлогын сорилт, чиг хандлага” сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, эдийн засгийн сорилтуудыг тал бүрээс нь харж, санал, бодол, байр сууриа илэрхийлэх боломж олгож байгаад талархаж байна. Улс орныхоо нийгэм, эдийн засагт тулгараад байгаа сорилтуудын талаар эрдэмтэн судлаачид, бизнес эрхлэгчид, иргэний нийгмийн төлөөлөл болон төрийн байгууллагуудын дунд нээлттэй хэлэлцүүлж, эдийн засгийн бодлогын чиг хандлагаа зөв тодорхойлох гэж байгаа нь Монгол Улсын цаашдын хөгжил, цэцэглэлтэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна. Монгол Улсын эдийн засгийн чиг хандлагыг оновчтой зөв тодорхойлохын тулд эдийн засаг ямар хандлагатай хөгжиж өнөөдрийг угтсаныг эргэн харж, зөв дүгнэх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтыг татахын тулд улс төрийн тогтвортой байдлыг бий болгож, хөрөнгө оруулагчдын эрсдэлийг бууруулах замаар хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж чадвал гадаад, дотоодын валютын орох урсгал нэмэгдэж, манай эдийн засаг төрөлжиж, уул уурхайн үнийн өсөлт, бууралтаас үүсэх эрсдэлийг даах чадвартай болж улмаар энэ эерэг нөхцөл байдал дээрээ тулгуурлан хөгжих нь манай улсын хөгжлийн зам гэж үзэж байна.

Иймээс энэ бүх тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх арга зам, шийдэл энэ чуулганаас гарна гэдэгт найдаж байна.

Эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө,

Хоёр өдрийн турш Та бүхэн “Эдийн засгийн бодлогын сорилт, чиг хандлага” сэдвийн хүрээнд бусад олон чухал сэдвүүдээр чөлөөтэй хэлэлцэн байр сууриа илэрхийлж, эдийн засагт тулгамдаад байгаа сорилтуудыг мэдэрсэн, өмнөх алдаа, сургамжаасаа суралцсан, эдийн засгийн бодлогоо зөв тодорхойлж шийдлээ олсон олон ажил, асуудлын ард хамтдаа гарцгаана гэдэгт огт эргэлзэхгүй байна.

Чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Чойжилсүрэн

УИХ-ын Төсвийн байнгын хорооны дарга



Хуралдаан 1:

Мөнгөний бодлогын хэрэгжилт, сургамж



Модератор:

Ж.Ганбаатар

Ерөнхий эдийн засагч-
Ерөнхийлөгчийн зөвлөх
Монголбанк

Илтгэгч:

Д.Болдбаатар

Ахлах эдийн засагч
Монголбанк, Мөнгөний
бодлогын газар

Хэлэлцүүлэгт оролцогчид:

Н.Энхбаяр

Ерөнхий сайдын ахлах
зөвлөх

Г.Батхүрэл

Эдийн засгийн бодлогын
газрын дарга
Сангийн яам

Ц.Батсүх

Профессор
Санхүү, эдийн засгийн их
сургууль

Д. Болдбаатар: Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд мөнгөний нийлүүлэлт нэмэгдсэн нь үйлдвэрлэлээс илүүтэйгээр эрэлтийг нэмэгдүүлэх нөлөөг үзүүлж, эдийн засгийн өсөлт саарах явцыг бууруулж чадаагүйн дээр гадаад, дотоод тэнцвэрт байдал алдагдах нөхцөлийг бий болгосон. Монголбанкны санхүүжилт нь тодорхой салбарын эсвэл зориулалт заасан хэлбэртэй байх нь мөнгөний бодлогын зорилтыг нь бүрдүүлж, ёс суртахууны доройтол (moral hazard) үүсгэсэн. Төв банкны зорилтыг хуулийн дагуу нарийвчлан тогтоож, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл жил бүр батлах байдлаар өрсөлдсөн бусад зорилт бий болохоос сэргийлэх нь зүйтэй. Монголбанкны санхүүжилттэй холбоотой эрх зүйн орчин сул, ялангуяа, Засгийн газарт олгох санхүүжилтэд хязгаар байхгүй. Төв банкны бие даасан байдлыг хамгаалсан институциональ тогтолцоо сул байна.

Ж.Ганбаатар: 2008 оны 5 сард АНУ-ын хамгийн том санхүүгийн байгууллагуудын нэг болох Бер Стернс дампуурсан. Дараа нь 9 сард Лейман Бродерс Ай-Жи дампуурсан. 2008, 2009 оны хямралын үед АНУ-ын Төв банкнаас уламжлалт бус мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Одоо болтол хэрэгжүүлсэн бодлогыг нь эдийн засагчид маргалдсан хэвээр байна. Тэр үед гарсан товчхон тоог дурдьяа. Жишээ нь: Нөөц мөнгөний хэмжээ Англи Улсад 2007-2013-ны хооронд 5 дахин, АНУ-д 3 дахин, Японд 1,5 дахин, Европын бүсэд 2 дахин нэмэгдсэн байдаг. Манай орны хувьд 7 их наяд төгрөгийн нийлүүлэлт хийсэн.

Н.Энхбаяр: Мөнгөний бодлого, төсвийн бодлого, бүтцийн өөрчлөлтийн бодлого болон гадаад худалдааны бодлогыг харилцан уялдаатай байвал эдийн засгийн өсөлтийг хамгийн оновчтой, хурдацтай байлгах боломж юм. Бүх шалтгааныг түүхий эдийн хамааралтай байдал өсөлт гэж хэлж болмооргүй байгаа юм. Монгол Улсын уул уурхайн экспортыг 80 хувь гэж үзвэл нүүрсний экспорт 30 хувийг эзэлж байна. Эцсийн боловсруулсан бүтээгдэхүүн бол нүүрсний экспортын биет хэмжээ юм. 2015 онд 14.4 сая тонн нүүрс экспортолж 550 сая ам.долларын орлого олсон. Харин 2017 онд 33 сая тонн экспортод гаргаж 2.2 тэрбум ам долларын орлого олсон. Энэ хооронд үнийн нөлөөлөл бий хэдий ч биет хэмжээг хоёр дахин өсгөж, орлогыг дөрөв дахин өсгөж болохоор байна. Биет хэмжээний хоёр нь бид нараас хамаарч буй хувьсагчийг бид нар жолоодох боломжтой тул 2017 онд амжилттай байсан. Бусад түүхий эд дээр мөн адилхан. Тиймээс бусад бодлогын уялдаа чухал юм.

Г.Батхүрэл: 2012-2016 оны мөрийн хөтөлбөрт орон сууцны зээлийн тогтолцоог шинэчлэх, барилгын материалыг эх орондоо үйлдвэрлэдэг болох гэх мэт ажлууд тусгагдсан. Энэ үед Оюу-Толгойн хэрэгжилтийн нэг дүгээр үе шат дуусаж, ГШХО-ын урсгал татарсан. Энэ үед 1.5 тэрбум төгрөгийн бонд босгосноор ГВАН нэмэгдэж мөнгөний нийлүүлэлтийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг хангах бодлого мөрийн хөтөлбөрт туссан байсан. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодлогын алдаа гарсан. Валютын нөөцийг нэмэгдүүлснээр их хэмжээгээр төгрөг зах зээлд нийлүүлж, ханшийн төлбөрийн тэнцэл дээр дарамт учруулж улмаар ханшид нөлөөлсөн. Үүнийг интервенц хийх замаар ханшийг барьж хатуу бодлого хэрэгжүүлсэн. Барилгын салбарын үйлдвэрлэлийг дэмжих санаа нь зөв байсан хэдий ч нийлүүлэлтийн гаралтай инфляцыг бууруулах байсан боловч инфляцын бүтцийг аваад үзвэл импортын барааны 41 хувь ханш дээр алдсан бол инфляцийн 40 хувь дээр сөрөг дарамт ирж байсан. Ийм холимог хувилбарууд байсан. Ж.Ганбаатар: 2008 оны 5 сард АНУ-ын хамгийн том санхүүгийн байгууллагуудын нэг болох Бер Стернс дампуурсан. Дараа нь 9 сард Лейман Бродерс Ай-Жи дампуурсан. 2008, 2009 оны хямралын үед АНУ-ын Төв банкнаас уламжлалт бус мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Одоо болтол хэрэгжүүлсэн бодлогыг нь эдийн засагчид маргалдсан хэвээр байна. Тэр үед гарсан товчхон тоог дурдьяа. Жишээ нь: Нөөц мөнгөний хэмжээ Англи Улсад 2007-2013-ны хооронд 5 дахин, АНУ-д 3 дахин, Японд 1,5 дахин, Европын бүсэд 2 дахин нэмэгдсэн байдаг. Манай орны хувьд 7 их наяд төгрөгийн нийлүүлэлт хийсэн.

Ц.Батсүх: Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсний дараа хүнсний бүтээгдэхүүн дээр хаврын эффект нь алга болоод намар дээр илүү улирлын нөлөөлөлтэй гарч ирсэн. Энэ дээр гарч ирсэн 2 зүйлийг харвал орон сууц, уур усны үнийн индекс өссөн. Нөгөө талаас боловсролын үйлчилгээний үнийн индекс өссөн. Тэгэхлээр авч хэрэгжүүлэхдээ хүнсний бүтээгдэхүүний үнэн дээр хяналтад оруулах гэж байгаа бол төрөөс хяналттай бүтээгдэхүүний үнийг зөв зохицуулах хэрэгтэй. Нэг бодлогын арга хэрэгсэл дээр зөрчилтэй бодлого явуулсан түүхэн сургамж байна. Энэхүү судалгааны үр дүнд валютын ханш 10 хувиар өсөхөд импортлогч компаниуд өсөлтийн 6 хувийг үнэ дээр гаргасан. Харин 4 хувийг нь импортлогч компаниуд зардал дээр шингээж байна. Тиймээс импортын компаниуд автоматаар 4 хувь доош бууна. Импортлогч нарт маш хүчтэй нөлөө үзүүлж байгаа нь харагдаж байна. Нөгөө талаас энэхүү 10 хувийн өсөлт хэрэглээний үнийн индексэд 2 хувийн нөлөөлөлтэй байна. Валютын ханшийн төгрөгийн өсөлт шилжиж байгаа механизм эрэлтийн инфляци дээр очиж нөлөөлж байгаа хэдий ч нийлүүлэлтийн инфляцын зардал дээр очиж давхар нөлөөлж байна.

Цаашид бид төсөв мөнгөний харилцан уялдаатай бодлогыг маш сайн барих хэрэгтэй.

**О.Орхон**

Гүйцэтгэх захирал
Худалдаа хөгжлийн банк

Цаашид Монголбанк мөнгөний нийлүүлэлтийг хийх нь зүйтэй гэж үзэж байна. Миний шүүмжлэх гэж буй зүйл бол Төсвийн бодлого мөнгөний бодлого хоёр их уялдаа муутай явсан гэж дүгнэсэн. Чингис бондыг босгосны дараа Засгийн газар төсвийн зардлыг их хэмжээгээр нэмж төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн. Үүнтэй зэрэгцээд Төв Банк мөнгөний нийлүүлэлтийг нэмж банкнуудаар дамжуулж үнэ тогтворжуулах хөтөлбөрийг явуулсан. Хэрэв Төв банк төсөв тэлж зардал ихэссэн үед мөнгөний бодлогыг хатууруулах арга хэмжээ авч бусад үед тэнцвэрийг хангасан бол ийм асуудал гарахгүй байх байсан. Үүн дээр алдаа гаргасан гэж үзэж байна. Төсөв, мөнгөний бодлогын уялдаагүй байдал, бодлогын зөрчилдөөн гэх мэт алдаанаас болж бодит амьдрал дээр шокуудыг бий болгосон. Тиймээс Төв банк тодорхой секторуудыг онилох, банкнуудад санхүүжилт олгох ажлыг үргэлжлүүлэхийг хүсэж байна.

Мөнгөний бодлого нь эдийн засгийн гол тулгуур салбаруудыг хөгжүүлэхэд нийцэж ажиллахгүй байна. Монгол Улсад валютын урсгалын хяналт байхгүй байна. 2017 онд “Эрдэнэс Таван Толгой”-гоос 20 сая тонн нүүрс дунджаар 20 ам.доллараар тээвэрлэсэн байдаг. Тээврийн зардалд 400 сая ам.долларыг Хятад руу гаргасан. Өнгөрсөн жил “Оюу Толгой” 160 сая ам.долларыг цахилгаан эрчим хүчний төлбөрт төллөө. Эдийн засгийг хөдөлгөж буй гол салбаруудын тээвэр, түлшний зардлаар гадаад валют буцаад урсаад алга болдог. Тиймээс Монголбанкыг бодит эдийн засаг дээрх мөнгөний хэмжээг тооцохыг хүсэж байна. Мөн энэхүү мөнгийг үлдээхийн тулд зохистой бодлогыг авч хэрэгжүүлэхийг хүсэж байна. Ханшны өөрчлөлтийн hedging нэвтрүүлмээр байна. Бодит төсөл болон төслийн санхүүжилтийг хэрэгжүүлбэл хамтарч ажиллахад бэлэн байна.

**Ц.Түмэнцогт**

Гүйцэтгэх захирал
“Эрдэнэс Монгол” ХХК

Банкны салбарын шинэчлэлтэй холбогдуулаад хоёр хууль батлагдсан. Төлбөр тооцоо болон банкны зээлийн хүүтэй холбоотой хууль шинэчлэгдэх гэж байна. Санхүүгийн зах зээлийг бүрдүүлдэг бусад салбарууд, жишээ нь хөрөнгийн зах зээл, даатгал зэрэг салбаруудын шинэчлэл зэрэг явах хэрэгтэй байна. Монголчууд алдсан алдаанаасаа сургамж авдаггүй. Энэ дундаас өмч хувьчлал бол үнэхээр алдаатай болсон. Монголын баялгийг нийт хүн амын гурваас дөрвөн хувьд ногдож байна. Засгийн Газрын хийх ажлуудын нэг бол бүтцийн өөрчлөлтийн бодлого юм. Төв банкны хуулийг сайжруулахын тулд ажилласан. Хамгийн гол нь хэрэгжүүлэх дээр алдаа гаргасан. Тиймээс бид авах олон сургамж байна гэж үзэж байна. Монголд боломжууд байна. 13 их наяд төгрөгийн хадгаламжтай байна. Энэхүү мөнгийг эргэлтэд оруулах болон хөрөнгийн биржийг хөгжүүлэхэд онцгой анхаарах хэрэгтэй. Мөн манай улс хөгжлийн загварыг өөрчлөх хэрэгтэй.

**Б.Баттөмөр**

УИХ-ын гишүүн

Манайд эдийн засгийн мөчлөгт орох хугацаа улам бүр багасаж байна. Бид нар эдийн засгийн уналт эсвэл өсөлтийг бий болгодог хоёр төрлийн аргачлал мэддэг болж байна. Тиймээс бидний анхаарах зүйл бол эдийн засгийг тогтвортой барих нь чухал байна. Манай эдийн засаг зөвхөн уул уурхайн салбараас хамааралтай, тийм учраас санхүүгийн салбар хүртэл нэг тулгууртай болсон. Хөрөнгийн зах зээл, банк болон даатгал гэж хамтарсан байдлаар явбал нөөцийг зөв зохистой хуваарилах ач холбогдолтой юм.

**С. Даваасүрэн**

Дарга
Санхүүгийн зохицуулах хороо

Э.Долгион

Ерөнхийлөгч
Монголын өдөр
тутмын сонины
холбоо

Монгол Улсын олон улс дахь нэр хүнд нэлээн буурсан. Өнгөрсөн 30 жилийн турш нэг Засгийн газрын дундаж наслалт нь 1 жил 3 сар байсан. Тиймээс бодлогын үр дүнг хараад хэрэгжүүлэх боломж их хязгаарлагдмал гэж хэлж болно. Блүүмберг терминал дээр 132 мянган функц байдаг, харин Монгол Улстай холбоотой зөвхөн 20 гаруй функц байдаг. Манай улсын эдийн засаг үүгээр харагдаж байна. Олон нийтэд тухайн мэдээллийг зөвөөр ойлгуулах нь чухал.

2018 оны эдийн засаг, санхүүгийн сорилтууд



Модератор:

О.Эрдэмбилэг

Тэргүүн Дэд Ерөнхийлөгч
Монголбанк

Илтгэгч:

Д.Ган-Очир

Захирал
Монголбанк, Судалгаа,
статистикийн газар

Хэлэлцүүлэгт оролцогчид:

А.Ариунзаяа

Дарга
Үндэсний статистикийн
хороо

Д.Баярсайхан

Дэд дарга
Санхүүгийн зохицуулах
хороо

Б.Батбаяр

Гүйцэтгэх захирал
Хөгжлийн банк

Ц.Мөнхбаяр

УИХ-ын даргын эдийн
засгийн зөвлөх

Д.Ган-Очир: Эдийн засаг 2016 оны хүндрэлээс 2017 оны туршид сэргэсээр шинэ оны босготой золголоо. Хэдийгээр эдийн засаг уналтаас дайжиж, тогтворжиж эхлээд байгаа боловч тогтворжилтыг баталгаажуулах, цаашдын тогтвортой өсөлтөд оруулахад цэгцтэй бодлого шаардлагатай хэвээр байна. Цаашдын төлөв байдлаас харахад 2018 онд эдийн засгийн өсөлт үргэлжилж, инфляцийн дарамт бага зэрэг нэмэгдэхээр байна. Гэхдээ эдийн засагт гадаад секторын болон бодлогын олон сорилтыг хэрхэн шийдвэрлэхтэй холбоотой тодорхой бус байдал байсаар л байна. Эдгээр сорилтыг хэрхэн амжилттай, шуурхай шийдвэрлэхээс эдийн засгийн хөгжлийн цаашдын чиг хандлага шууд хамаарна. Бодлогын үр дүн нь шийдвэр гарах ёстой цаг үед (жишээлбэл, үүлэн чөлөөний нарыг ашиглан)-ээ, хамрах ёстой хүрээгээ зөв хамарсан эсэхээс шууд хамаардаг. Иймд шаардлагатай шийдвэр (жишээлбэл, гадаад өрийн дарамтыг шийдвэрлэх, өрхийн өр, зээлийн дарамтыг багасгах, байгалийн баялагтаа тулгуурлан эдийн засгаа төрөлжүүлэх)-ийг судалгаа, шинжилгээнд үндэслэн зоримог гарган хэрэгжүүлснээр улс орны хөгжлийг түргэсгэнэ гэдэгт итгэлтэй байна.

А.Ариунзаяа: Статистикийн байгууллага бол бодлогыг гаргадаг, ярьдаг байгууллага биш, бодлогыг дүгнэдэг байгууллага юм. Манай байгууллага нь 93 жилийн түүхтэй, энэ түүхэндээ Монгол улсын нийгэм, эдийн засгийн түүхийг тоогоор илэрхийлэн авч үлдсэн. Хөгжлийн бүх үеийг тоогоор харуулдаг. 2017 оны чухал тоон мэдээллийг та бүхэнд танилцуулахаар богино хэмжээний илтгэл бэлтгэн авчирлаа. Өнгөрсөн жилийн эдийн засгийн үзүүлэлтүүд маш сайжирсан. Ургац хураалт 40 хувь алдсан боловч үүнээс бусад гол үзүүлэлтүүд эерэг гарсан. Харин нийгмийн үзүүлэлтүүд муу гарсан. Өнөөдрийн эдийн засгийн хямрал нийгэмд маргааш нь мэдрэгддэг. Харин өнөөдрийн эдийн засгийн дэвшил нь маргааш нийгэм дэх хувь хүний амьдралд мэдрэгдэнэ. Тиймээс бид улам хичээж ажиллаваас нийгмийн үзүүлэлтүүд маань сайжрах учиртай.

Д.Баярсайхан: Макро эдийн засгийн үзүүлэлтүүд 2017 онд эерэг дүр зурагтай гарсан байна. Үүнтэй адилаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2017 оны байдлаар 2 их наяд 436.3 тэрбум буюу өмнөх өндөр өсөлттэй жилүүдтэй адил гарлаа. Үүнийг бүтцээр нь задлан үзвэл хөрөнгийн зах зээлийн арилжааны 90 хувь нь засгийн газрын үнэт цаас байна. СЗХ-ноос давхар бүртгэлийг хөнгөвчлөх зорилготой журам баталсан ба энэ олон улсын 29 хөрөнгийн бирж дээр хүлээн зөвшөөрөгдсөн байна. Тиймээс олон улсын зах зээлд хувьцаа гаргасан уул уурхайн компаниуд маань дотооддоо үнэт цаасаа арилжих боломжтой болсон. СЗХ-ны хувьд УИХ-ын тогтоолын дагуу 2020 он хүртэл 17 хуулийг шинэчлэн найруулах, өөрчлөх ажил хийгдэнэ. Бидний хувьд 2018 оныг хууль, эрх зүйн реформ хийх жил болно хэмээн найдаж байна. Дараа дараагийн хууль, эрх зүйн зохицуулалтуудыг техник, технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг аль болох дэмжсэн байдлаар зохицуулах зүйтэй юм.

Б.Батбаяр: Монгол улсын хөгжлийн банк бол экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох төслүүдийг хөдөө аж, ахуй, уул уурхай, эрчим хүч дэмжсэн салбаруудад хэрэгжүүлнэ гэж 2018 оны төлөвлөгөөнд тусгасан. 2017 оны эцэст банкны балансаа цэвэрлэж, 1 их наяд төгрөгийн зээл, өр төлбөр барагдуулсан. Хөгжлийн банкны дэргэд 2 тусгай зориулалтын компани байгуулсан. Үүний нэг нь уул уурхай, хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбарт лизингийн үйл ажиллагаа явуулах, том хэмжээтэй, урт хугацаатай эх үүсвэр оруулж ирснээр тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх зориулалттай. Нөгөө нь хөрөнгө оруулалтын менежментийн компани байгуулаад, өнгөрсөн онд тусгай зориулалтын компани байгуулах зөвшөөрлөө авсан. Энэ дагуу хөдөө аж ахуйн, дэд бүтцийн, ногоон сангийн 3 хөрөнгө оруулалтын сан байгуулахаар ажиллаж байна. Үүний гол зорилго нь Монгол улсын хэмжээнд урт хугацаанд өгөөжөө өгөх төслүүдийг гадаадын зээлээр биш хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх, гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах зорилготой. Энэ ондоо багтаад эхний хөрөнгө оруулалтын сангаа байгуулах төлөвлөгөөтэй байна. 2018 онд богино болон дунд хугацаанд өгөөжөө өгөх төслүүд дээр түлхүү ажиллаж байна. Эхний ээлжинд Монгол улсын экспортод голлох байр суурь эзэлдэг ноолуурын салбарын дотоодод боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлэх, бусад экспортын боломжуудыг дэмжихээр ажиллаж байна.

Ц.Мөнхбаяр: Юуны өмнө 2018 оны сорилтын тухайд хоёр сорилт байна гэж үзэж байна. Нэгт одоогийн эдийн засгийн өсөлтийг тогтвортой байлгах, хоёрт уг өсөлтийг хүртээмжтэй байлгах юм. Тогтвортой байдлыг хангахын тулд өрсөлдөх чадвараа сайжруулах, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих нь чухал юм. Хүртээмжтэй байдал буюу эдийн засгийн өсөлтийг өрхөд хүргэхийн тулд тэгш боломжийг бий болгох буюу боловсрол, эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх мөн ажлын байр бий болгох шаардлагатай. Ажлын байр бий болгохын хажуугаар бүтээмжийг нэмэгдүүлэх нь зүйтэй. Мөн засгийн газрын шилжүүлэг буюу татаас, тусламжийг яг зорилтот бүлэгт хүргэх тал дээр анхаарах хэрэгтэй. Бид хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг 2015 онд баталсан. Мөн 2016 онд 2030 он хүртэлх зорилтуудаа баталсан. Энэ хууль, үзэл баримтлал батлагдахаас өмнө батлагдсан олон төрөөс баримтлах бодлогууд байгаа ба эдгээрийг цэгцлэх, уялдуулах, нийцүүлэх, ажлууд байгаа. УИХ-ын даргын зүгээс 2018 онд өмнө дурдсан бодлогын асуудлыг эцсийн үр дүн гарах хүртэл манлайлж ажиллана. Түүнчлэн хэрэгжилтэд өмнөх жилүүдээс илүү хяналт тавьж ажиллана. Эцэст нь хэлэхэд бид бодлогын асуудлаа олон нийтэд сайн танилцуулж, хариуцлагын асуудлыг сайжруулах, мөн үр дүнгээ зөв дүгнэх нэгдсэн хэмжүүртэй байх шаардлагатай.

**... экспортыг
нэмэгдүүлэх,
импортыг орлох
төслүүдийг
хөдөө аж, ахуй,
уул уурхай,
эрчим хүч
дэмжсэн
салбаруудад
хэрэгжүүлнэ**



**Х.Бадамсүрэн**

Гүйцэтгэх захирал
“Эрдэнэт үйлдвэр” ХХК

Эрдэнэт үйлдвэрийн экспортын орлогыг богино хугацаанд тэрбум долларт хүргэх зорилт тавин ажиллаж байна. Уул уурхайн үйлдвэрийн хувьд хэтийн төлөвөө урт хугацаанд гаргадаг бөгөөд Эрдэнэт үйлдвэрийн хувьд ирэх 15 жилд баримтлах бодлогоо гаргасан. Үүнд, нэгдүгээрт техникийн, хоёрдугаарт технологийн, гуравдугаарт эдийн засаг, санхүүгийн бодлогыг авч үзсэн. Эрдэнэт үйлдвэрийн хувьд 2018 онд тулгарч буй нэг сорилт нь уул, геологийн нөхцөл хүндэрч байгаа явдал юм. Бид үүнийг металл авалтыг дээшлүүлэх замаар даван туулна. Мөн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн насжилт өндөр байна. Тиймээс нийт тоног төхөөрөмжийн 55-70 хувийг шинэчлэх шаардлага тулгарч байгаа юм. Улсын хэмжээнд тулгарч буй сорилт, бэрхшээлийн хувьд салбаруудын уялдаа холбоог хангах, төлөвлөлт болон гүйцэтгэлийг нийцүүлэх нь их чухал юм.

Эрдэнэт үйлдвэр бол энэ салбартаа Монгол улсын түүчээ байгууллага. Манайд 40 гаруй эрдэмтэн, судлаачид ажиллаж, уул уурхайн бодлогын талаар судалгаа, тооцоолол хийж байдаг. Энэ чуулганаар мөнгөний болон төсвийн бодлого, салбарын бодлогыг нэгтгэх, макро эдийн засгийн сорилтуудыг микро эдийн засгийн асуудлуудтай уялдуулах өндөр ач холбогдолтой юм. Манай улсад хуулийг чанартай, давхар ойлголтгүй, хүрсэн түвшнээсээ ухардаггүй байх хэрэгтэй. Өнөөдөр дэлхий нийт борлуулалтын орлогоос ашигт малтмалын татвараа төлдөг. Манай улсад борлуулалтын орлогын үнэлгээг төв байгууллагууд журмаар зохицуулдаг нь хуулиас өндөр журам болоод байна. Эрдэнэт үйлдвэр 2017 онд 17 хувийн ашигт малтмалын татвар төлсөн. Бид металл авалтын хувийг жил болгон өсгөж ирсэн ба одоо 89.2 хувь байна.

Б. Чойжилсүрэн: 2017 оны эхэн үед зорилт, сорилт маань одоо үеэс өөр байсан. Хамгийн тулгарч байсан зорилт, сорилт бол өрийн тогтвортой байдлыг хангах, эргэн төлөлт тулсан хүнд үеийг Монголбанк, Засгийн газар хамтраад амжилттай давсан гэж дүгнэж болно. Бид дефолтоос зугтсан гэж болох ч баярлах цаг нь болоогүй байна. Өрийн хэмжээ өсч байгаа энэ хүнд нөхцөл байдлаас бид хэрхэн гарах вэ. Ямартай ч цаг нь тулгамдсан өрийн асуудлыг шийдэж чадсан. Хаврын чуулганаар санхүүгийн салбарын, татварын бодлогын 3 том хуулийн төслийг хэлэлцэхээр байгаа. Ч.Улаан гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг ажиллаж байгаа ба Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Хувь хүний орлогын албан татварын хуулийг энэ хаврын чуулганаар хэлэлцэж эхэлнэ. Энэ үед зарим нэг асуудалд анхаарал хандуулах хэрэгтэй байна. Бизнесийн зээл авсан зээлдэгч олон эрсдэлийг даваад нэмүү өртөг бүтээдэг. Харин хэрэглээний зээл бол өмнө нь бий болсон нэмүү өртгийг барьцаалж байгаа явдал юм. Тиймээс валютын эрэлтийг нэмэгдүүлдэг хэрэглээний зээлийн зарим хэсэгт татвар тавихыг үгүйсгэхгүй.

**Д.Галбаатар**

Орлогч дарга
“Эрдэнэт үйлдвэр” ХХК,
Эдийн засаг, маркетингийн хэлтэс



Д.Дамба-Очир (зүүн), Б.Чойжилсүрэн (баруун)

УИХ-ын Эдийн
засгийн байнгын
хорооны дарга

УИХ-ын Төсвийн
байнгын хорооны
дарга

Д.Дамба-Очир: Монгол улсын засгийн газар БНХАУ-ын засгийн газартай түншлэл, стратегийн асуудлуудаа шийдэхгүйгээр цааш явахгүй. Үгүй бол Тавантолгой, төмөр зам, нүүрсний экспортын асуудлууд шийдэгдэхгүй. Өнгөрсөн жил ОХУ, БНХАУ-ын засгийн газрууд стратегийн түншлэлийн асуудлаа шийдэж, тохиролцож чадсан учраас ганцхан жилийн дараа ОХУ нь БНХАУ-ын коксжих нүүрсний хэрэглээний 30 хувийг эзэлж байна. Асуудлыг энэ зарчмаар шийдэж явах нь зүйтэй. УИХ-ын эдийн засгийн байнгын хороон дээр уул уурхайн бус экспортод чиглэсэн хөнгөн үйлдвэр, ноос, ноолуур, арьс ширний үйлдвэрүүдийг дэмжих талаар ажиллаж байна.

**О.Банзрагч**

Тэргүүн дэд захирал
Улаанбаатар хотын
банк

УИХ-ын даргыг эдийн засгийн бодлогын зөвлөхийн хэлсэн бүтээмж нэмэгдүүлэх нь маш зөв сэдэв. Монгол улс бол уул уурхайд суурилсан эдийн засагтай. Манай улсад өрсөлдөх чадварын, өртгийн асуудал байдаг. Тодруулбал, тээврийн асуудал. Үүнийг бүгд мэддэг боловч шийдэхгүй байна. Түүхий эдийн үнэ бол хэлбэлзэл өндөртэй, байнга одоогийн түвшиндээ өндөр байхгүй. Уул уурхайн компаниуд нүүрс, төмрийн хүдрээ өртөг багатайгаар экспортлохын тулд ложистикийн компани болж хувирсан байна. Энэ асуудал дээр Хөгжлийн банк анхаарал хандуулах хэрэгтэй. Ойрын 2-3 жилдээ тээврийн асуудлаа шийдээд, дотоод дахь өртгөө бууруулах хэрэгтэй. Мөн УИХ-ын төсвийн байнгын хорооны дарга Б.Чойжилсүрэнгийн тавьсан хэрэглээний зээлтэй холбоотой асуудалтай санал нэг байна. Банкууд хэрэглээний, тэтгэврийн, цалингийн зээл рүү их хошуурч байна. Эдгээр нь импортыг дэмжсэн зээл боловч бид эрсдэлээ тархаан байршуулах шаардлагатай байдаг. Үүнд Монголбанк бодлогын хувьд арга хэмжээ авах боломж бий. Өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх замаар тэтгэвэр, цалингийн зээлийг хязгаарлах боломжтой. Арилжааны банкууд ашгийн байгууллага боловч бодлогын шийдвэрүүдийг зайлшгүй дагах болно. Экспортыг дэмжсэн төслүүдийг Хөгжлийн банк болон арилжааны банкууд дэмжээд явах маш зүйтэй санал байна. Эцэст нь хэлэхэд тээврийн салбар дахь өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх шаардлагатай байна. УБТЗ-ын өртөг хэт өндөр байна. Дэлхийн жишгээс 3, 4 дахин үнэтэй байгаа тохиолдолд хувийн хэвшлийнхэн бизнес хийгээд ашиг олно гэдэг хүндрэлтэй. Энэ тал дээр та бүхнийг анхаарал хандуулаасай гэж хүсч байна.

Д.Ган-Очир захирлын илтгэлд байсанчлан байгалийн баялгийг эдийн засгийн өсөлтөд ашиглах нь гэдэг зүйл нь хамгийн чухал зүйл бөгөөд бидний алдаад байгаа зүйл. Байгалийн нөөцийн орлогоор оновчтой хөрөнгө оруулалт хийх гэдэг бас бидний том алдаа. Бидэнд мөнгө байсан боловч оновчтой зарцуулж чадаагүй. Цаашдаа бид том төслүүдээ хэрэгжүүлэх тал дээр анхаарах нэг асуудал байна. Манай салбар яамдууд төсөл хэрэгжүүлэхээр танилцуулахдаа 4-5 жилд хэрэгжүүлнэ гэдэг. Гэвч хамгийн ойрын амжилттай явж байгаа нэг жишээ болох Хөшигтийн хөндийн нисэх онгоцны буудал бол төсөл нь бэлэн, хөрөнгө оруулагчид нь бэлэн байсан боловч 10 жил хэрэгжиж байна. Тиймээс шинээр хэрэгжүүлэх төслүүдийн тооцооллоо бодит байдалтай нийцүүлж байгаасай гэж хүсч байна. Мөнгөний, төсвийн бодлого бүх зүйлийг шийдэж чадахгүй учир эдийн засгийн сууриа зөв бэхжүүлэхэд бүтцийн өөрчлөлтийн бодлого чухал үүрэгтэй юм.

**Н.Энхбаяр**

Ерөнхий сайдын эдийн засгийн бодлогын зөвлөх

**Г.Батхүрэл**

Дарга
Сангийн яам,
Эдийн засгийн
бодлогын газар

Сангийн яамны хувьд 2018 оны эдийн засгийн тооцоо прогноз гаргасан нь Монголбанкны тооцоололтой ерөнхийдөө адилхан, бага зэргийн зөрүүтэй байна. Экспортын удаашрал үүссэн учраас 2017 онд гарсан шиг экспортыг дагасан худалдаа, үйлчилгээ, тээврийн салбарын өсөлтийг төсөөлөхөд эрсдэлтэй гэж үзэж байна. Зэсийн үйлдвэрлэлийн хувьд, Эрдэнэт үйлдвэр олон жилийн дунджийнхаа дагуу үйлдвэрлэлээ явуулсан. Харин Оюутолгой компанийн зэсийн агууламж 22 хувиар, алтны агууламж 2.8 дахин буурсан. Үүнээс харахад 2018 онд зэсийн биет хэмжээний агууламж 10 гаруй хувиар буурч, алтны агууламж нэмэгдэхээр байна.

**Б.Баттөмөр**

УИХ-ын гишүүн

Бидний өнгөрсөн хугацаанд орхигдуулж ирсэн нэг асуудал бол зах зээлийн хүлээлтээр дамжуулж бодлого явуулж буй байгууллагуудын нэр хүндийн асуудал юм. Төв банк, Сангийн яам, Хөгжлийн банкны үйл хөдлөлд хувь хүн, байгууллагууд итгэж байж шийдвэрээ гаргадаг. Гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын хэмжээ, дотоодын байгууллагуудын шинээр ажлын байр бий болгож буй хэмжээ зэрэг нь эдгээр байгууллагуудын тооцоо, төсөөлөл, мэдэгдэл дээр үндэслэж гаргадаг учир эдгээр байгууллагуудын нэр хүндийн асуудал тун чухал болоод байна. Түүнчлэн төрийн оролцоог зохистой түвшинд хязгаарлахгүй бол эргээд төр дээр, төсөв дээр ирэх ачаалал нэмэгдэж байна. Өрийн дарамтыг татвараар л бууруулдаг учраас энэ нь эргээд асуудал болж байна. Одоо нэмэгдэж буй 7 төрлийн татвар нь бодлогын зарчим алдагдсанаас үүдэн эдийн засаг, санхүүгийн нөөц шавхагдсантай холбоотой буюу өнгөрсөн үеийн бодлогоос гарч буй зардал юм. Цаашид бид аливаа бодлогыг төлөвлөхдөө дараа нь уг бодлогоос хэрхэн дарамт багатай, шок багатай гарах вэ гэдэгт анхаарах хэрэгтэй. Үгүй бол энэ нь эргээд эдийн засагт сөрөг шок болж орж ирдэг нь 2014-2016 онд харагдлаа. Тухайн хугацаанд хийсэн санхүүжилтийн хэмжээ 20 их наяд төгрөг буюу Монгол улсын нэг жилд үйлдвэрлэдэг бүтээгдэхүүнтэй тэнцэхүйц байгаа. Монголбанкнаас 7 их наяд, Хөгжлийн банкнаас 5 их наяд, Засгийн газрын өрийн хэмжээ уг хугацаанд 12 их наяд төгрөгөөр нэмэгдсэн. Энэ их хэмжээний мөнгийг эдийн засагт нийлүүлсний дараа ямар үр дүнд хүрсэн бэ гэдгийг харвал тун харамсалтай үр дүн харагдана. Ажилгүйдэл 6 хувиас 12 хувь хүрээд эргээд 9.7 хувь болж буурч байна. Өрхийн бодит орлогын хэмжээ 2012 оны түвшнээс буурсан бол нэрлэсэн орлого нь ердөө 20 хувиар нэмэгдсэн байна. Эдийн засгийн нөөц бололцоог энэ их хэмжээнд шавхсаны дараагаар нөхцөл байдал ийм байгаа нь харамсалтай.

**Г.Дөлгөөн**Гүйцэтгэх захирал
Төрийн банк

ОУВС-тай тохиролцсоны дагуу нэмэгдсэн татварын нэмэгдлийг Монголчууд даваад гарч чадвал эдийн засагт их хэрэгтэй, зөв хандлага ирэх юм. Татвар гэдэг бол эдийн засгийг зохицуулах хөшүүрэг юм. Өнөөгийн нийгэм бол татвар дээр суурилж хөгжих ёстой. Гэтэл татвар нэмэхгүйгээр Монгол улс яаж хөгжих вэ гэсэн том сорилттой тулгарч байна. Үүнийг ойрын хугацаанд шийдэх нь зүйтэй гэсэн саналтай байгаа. Өнөөдрийн илтгэлд дурдагдсан гадаад өрийн дарамт, ядуурал, өр, зээлийн дарамт, байгалийн баялгийг эдийн засгийн хөгжилд ашиглах 3 сорилттой санал нэг байна. Монгол улс нийт баялгийн хэмжээгээрээ дэлхийд 15-д, нэг хүнд ногдох баялгийн хэмжээгээр дэлхийд тэргүүлдэг. Өнөөдөр баялгийн менежментдээ анхаарах шаардлагатай. Энэ нь цаашид Монгол улс хөгжих үү, эс хөгжих үү гэсэн асуудал юм.

**Б.Баярдава**Захирал
Монголбанк,
Мөнгөний
бодлогын газар

Баялгаа зөв хуваарилж, олсон орлогоо зөв зохистой зарцуулах хэрэгтэй. Стратегийн өндөр ач холбогдолтой том төслүүдэд эх үүсвэрийн асуудал байна. Сүүлийн 1-2 жилийн хугацаанд манай улсын санхүүгийн рейтинг буурсан тал бий. Гэхдээ сайн тал нь энэ жилдээ рейтинг өсч эхэлж байгаа ба үүнтэй холбоотойгоор манай эх үүсвэрийн зардлууд буурч байна. Баялгийг зөв хуваарилж стратегийн томоохон ач холбогдолтой үйлдвэрүүд байгуулж, орлогыг нэмэгдүүлж байж үүгээр дамжуулан ядуурлыг бууруулах боломжтой. Тиймээс баялгаас орж ирж буй орлогыг зөв зохистой зарцуулж, мөн эх үүсвэрийн зардлыг бууруулах шаардлагатай байна. Төрийн байгууллага, арилжааны банкууд, санхүүгийн байгууллагууд нэгэн зорилготойгоор хамтран ажиллаж чадвал бүх ачааг даван туулж чадна.

Хуралдаан 3:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа, крипто валют, цахим мөнгө: Бидний байр суурь



Модератор:

Б.Лхагвасүрэн
Дэд Ерөнхийлөгч
Монголбанк

Илтгэгч:

Б.Энхбаяр
Дэд сайд
Хууль зүй, дотоод хэргийн
яам

Хэлэлцүүлэгт оролцогчид:

Х.Батчулуун
Дарга
Монголбанк, Санхүүгийн
мэдээллийн алба

Б.Батзориг
Дарга
Санхүүгийн зохицуулах
хороо,
Захиргаа удирдлагын газар

Э.Анар
Захирал
Монголбанк, Төлбөр
тооцооны газар

Б.Энхбаяр: FATF буюу ФАТФ нь улс орнуудад Мөнгө угаах терроризмоос урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох зөвлөмжийг өгч ажилладаг. Одоогийн байдлаар ФАТФ-ын зүгээс 40 орчим зөвлөмжийг гаргасан бөгөөд үүнийг манай улс хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн үнэлгээгээр манай улс 5 нь хангалтгүй, 15 нь дийлэнх хангалттай, 5 нь зарим нь хангалтгүй, 5 нь хангалттай гэсэн үзүүлэлттэй байна. ФАТФ-ын дотоод журмын дагуу 8 буюу түүнээс дээш хангалтгүй, зарим нь хангалтгүй гэсэн үнэлгээ авсан тохиолдолд эрчимтэй хяналтад ордог бөгөөд манай улсын хувьд энэхүү хяналтад орсон. 15 сарын эрчимжүүлсэн хяналтын хугацаанд нэн тэргүүнд хийгдэх ажлын төлөвлөгөөний хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамнаас “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийг боловсруулж, 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтоод байна. Ингэснээр Монгол Улсын ажиглалтын үе буюу 2018 оны 10 дугаар сараас өмнө ФАТФ-ын 40 зөвлөмжид хууль, эрх зүйн орчинг нийцүүлж, хэрэгжүүлснээр эрчимтэй хяналтаас гарах боломж бүрдэнэ.

Манай улс ФАТФ-ын “саарал жагсаалт”-д орох эрсдэлээс урьдчилан сэргийлж чадсанаар санхүүгийн системийн гадаад харилцаанд шууд нөлөөлж түншийн харилцаа зогсонги байдалд орох, хөрөнгө татах боломж буурах буюу хязгаарлагдах, банкуудын гадаад гүйлгээ зогсох гэх мэт манай улсын эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд шууд нөлөөлөх сөрөг үр дагавраас сэргийлж чадах ач холбогдолтой юм.



Х.Батчулуун: Техникийн хэрэгжилтийн болон үр дүнтэй байдлын үнэлгээ нь хоорондоо ямар ялгаатай эсэх талаар тайлбарлах нь зүйтэй болов уу. Техникийн үзүүлэлт нь тухайн орны хууль эрх зүйн орчны тогтолцоог үнэлдэг бол үр дүнгийн үзүүлэлт нь МУТСТ талаарх хууль эрх зүйн орчин нь хэрхэн бодитойгоор ажиллаж байгаа эсэх, хэрэгжилт нь ямар түвшинд байгаа эсэхийг дүгнэдэг. Өөрөөр хэлбэл зарим орнуудад хууль эрх зүйн орчин байгаа боловч түүний хэрэгжилт муу, практик дээр сайн ажилладаггүй асуудал гардаг. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд ФАТФ-ын байгууллага нь үр дүнгийн үнэлгээ гэсэн шалгууруудыг оруулж ирсэн. Манай улсын хувьд та бүхний харсанчлан хууль эрх зүйн орчин нь бүрдсэн боловч зохицуулалт, хэрэгжилт муу байна. Иймээс бид энэ оны 10 дугаар сард багтаан хуулиа батлуулах, цаашлаад хэрэгжилтийн асуудлыг анхаарах шаардлагатай байна.

Б.Батзориг: Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2017 онд 60 гаруй хянан шалгалт хийсэн. Гэвч банк бус санхүүгийн байгууллага олон оролцогчтой, бүх байгууллагад хянан шалгалт хийх хэцүү учраас ирцэд суурилсан хянан шалгалтыг хороо эрчимжүүлж байна. Энэ чиглэлээр 2018 онд ирцэд суурилсан хянан шалгалтад ашиглах програм хангамжийг эхлүүлсэн. Санхүүгийн Зохицуулах Хорооноос бохир мөнгө орж ирэх бүх сувгийг хааж байна. Тийм учраас бүртгэл зөвшөөрөл дээр хяналт шалгалтын ажлууд нэлээд сайжирсан. Урт хугацааны даатгалын салбар дээр мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх эрсдэл байна. Ганц даатгалын компани байгаа хэдий ч даатгалын компаниар хийлгэж буй амь насны даатгалыг хийх гэрээг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд тавьж буй олон улсын шаардлагад нийцүүлэх үйл ажиллагааг хийж байна. Санхүүгийн Зохицуулах хорооны зохицуулалтад байдаг байгууллагад криптовалюутай холбоотой асуудлаас хол байхыг сануулж ажиллаж байна.

Э.Анар: Монголбанк 2017 оны сүүлийн хагаст ажлын хэсэг байгуулж криптовалюутай холбоотой судалгаанууд хийсэн. Монголын нийт криптовалют, биткойныг судалсан байдлыг газар нутгаар нь авч үзвэл хувьд Өмнөговь аймагт Улаанбаатар хотоос 4 дахин их, Орхон аймагт 3 дахин их хайлтыг гүүглээр хийсэн байна. Хүмүүс криптовалютад хөрөнгө оруулснаар ашиг олох боломжтой гэж бодоод байна. Засгийн газрын түвшинд зарим сайд нар криптовалютын мөн чанар болон эрсдэлийг харахгүйгээр дэмжсэн байдал ажиглагдсан. Монголбанкны зүгээс бэлэн бус төлбөр тооцоог илүү амар, шуурхай болгох зорилгоор тооцож ажиллаж байна. Монгол Улсын хэмжээ том учир банкны салбар хүрэхгүй байх цэгүүд байна. Энэ хэсгүүдэд санхүүгийн хамгийн зөв шийдэл бол технологи дээр суурилсан Финтекийг хөгжүүлэх юм.

**Монгол Улсын
ажиглалтын үе
буюу 2018 оны 10
дугаар сараас
өмнө ФАТФ-ын
40 зөвлөмжид
хууль, эрх зүйн
орчинг нийцүүлж,
хэрэгжүүлснээр
эрчимтэй
хяналтаас гарах
боломж бүрдэнэ.**



**Б.Баттөмөр**

УИХ-ын гишүүн

ФАТФ байгууллагын манайд өгсөн сануулга бол их ноцтой. Цаашид энэ маягаар явбал Монгол Улсын хөрөнгө оруулалт, зээл, корреспондент банкуудтай харилцах харилцаа таслагдах аюултай. Тиймээс ФАТФ-ын шаардлагыг биелүүлэх хэрэгтэй болж байна. Бид нараас асуулгүйгээр хар жагсаалтад оруулах эрсдэл байгаа тул анхаарч ажиллах хэрэгтэй байна. Манай терроризмтой тэмцэх хууль тийм их муу хууль биш. Гол нь хуулийг хэрэгжүүлэх хэрэгтэй.

2007 онд Үндэсний Статистикийн Хорооны Дэмбэрэл даргын хийсэн судалгаагаар далд эдийн засагт 27 хувьтай гэж гарсан байдаг. Сүүлд далд эдийн засаг 18 хувьтай болсон гэж сонссон. 2018 оны төсвийг хэлэлцэх үед манай ДНБ-ний хэмжээ 30.4 их наяд төгрөг байна. Монголд хурааж авч буй татварыг 30.4 их наяд төгрөгтэй харьцуулахаар Монгол Улс өндөр татвартай улс болж байна. Тиймээс бид ДНБ-ийг зөв тооцож байна уу 2 НӨАТ-ийн урамшууллын систем нэвтэрснээр урамшууллын нийт хэмжээ ДНБ-тэй харьцуулахад асар их зөрүүтэй гарч байна. Энэ асуудлуудыг бид цэгцлэх хэрэгтэй байна. Монгол Улсын цаашдын хөгжил, татварын суурийг нэмэгдүүлэх, албан бус хөдөлмөр эрхлэлтийг багасгах, далд эдийн засгийг багасгах энэ чиглэлд энэ хууль чиглэгдэх ёстой юм.

Ер нь бол эдийн засаг тогтвортой байх ажлын хүрээнд банкны системийн тогтвортой байдал хамгийн чухал. Банкнуудад хийгдэж буй AQR-ийн үнэлгээ болон бүтцийн өөрчлөлттэй холбоотой Төв банкны хуульд орсон өөрчлөлтүүд нь банкны системийн нэг хэсэг юм. Нөгөө хэсэг нь хадгаламжийн даатгалын тогтолцоо юм. Энэхүү хууль 2013 онд батлагдсан. Хуулийн хамгийн гол зорилго бол жижиг хадгаламж эзэмшигчдийн эрхийг хамгаалах байдаг. Өөрөөр хэлбэл банкнууд өөрсдийн мөнгөнөөс хураамж төлж, сан үүсгэж, арвижуулснаар банк дампуурах асуудал үүсвэл хадгаламж эзэмшигчдийн мөнгийг тэр сангаас тавьж олгодог тогтолцоо явж байна. Өнгөрсөн хугацаанд 2017 оны эцсийн байдлаар 337 тэрбум төгрөг байна. Нийт 14 банк байхад нийт харилцах, хадгаламжаар нь жагсааж байгаад тухайн банкнуудыг жагсаавал доод талын 9 банкиг нэгэн зэрэг 337 тэрбум төгрөгөөр хадгаламж эзэмшигчдийн мөнгийг тавьж олгож болно. 2013 онд хуулиар 20 сая төгрөг гэж баталсан. Сангийн хөрөнгө өсөх тусам 20 сая төгрөгийн хэмжээ өсөөд явах ёстой.

Х.Бум-Эрдэнэ

Гүйцэтгэх захирал
Хадгаламжийн
Даатгалын
Корпораци

**Р.Мөнхтуяа**

Гүйцэтгэх захирлын
тэргүүн орлогч
ХААН банк

Банкууд өөрсдөө мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг дүрэм гаргаж дотоодод мөрдөж буй харилцагчдын мэдээллийг шинэчилдэг. Харилцагчдын анхан шатны мэдээлэл олон улсын жишигт нийцсэн. Ажилтнуудын хүрээнд байнгын сургалт явуулж байна. Жилдээ 1-ээс 3 удаа захирлаас авахуулаад теллер хүртэл энэ шалгалтыг өгөөд явдаг хэмжээнд очсон. Гэсэн хэдий ч сүүлийн 3 жилийн дотор манай банкны хувьд долларын клирингийн данснуудыг хаалгасан. Ирээдүйд бий болох гэж буй аюул өнөө маргаашгүй болсон. Үлдсэн нэг, хоёр данс дээр анхааруулга авсан. Сүүлийн үед гадаад төлбөр тооцоо хийх гүйлгээн дээр байнга асуулга явагддаг болсон. Тиймээс комплаинсийн баг маань нэлээн томорсон. Гадаад төлбөр тооцоо хийдэг хүмүүс маань их ойрхон сууж байгаад бүх асуулган дээр яаралтай хариулдаг байдалтай байна. Ийм хэмжээнд хүрсэн байна. Энэ дээр анхаарал хандуулаад яаралтай оруулж өгөөрэй гэсэн хүсэлт тавимаар байна. Банкнуудын зүгээс бүх төрлийн мэдээллээр хангаж хамтарч ажиллахад бэлэн байгааг хэлмээр байна. Долларын клиринг хэцүү болохоос гадна, дагалдаад харагдахгүй байгаа зүйл гэвэл Виза, Мастер, Юнион Пэй картуудын төлбөр тооцоо доллароор явж байдаг. Долларын клиринг хаагдсантай холбоотой өдөр болгоны settlement-ийг тухайн орой хаахаар гол данснууд хаагдсан болохоор бид еврогийн дансыг ашиглаж байна. Банкууд энэ дээр алдагдал хүлээгээд явж байна. Duo currency-төгрөгөөр байгаа картуудыг бүгдийг долларт хөрвүүлээд өөр валютаар хийхээр банкнуудад зардалтай байна. Энэ дээр анхаарч ажиллахыг хүсэж байна.

Монголбанк дээр цахим бүртгэлийн settlement-үүдийг банкуудтай хамтарч ажиллах боломж байдаг болов уу? Өмнө нь бидний зүгээс гадаад валютын клирингийн дансыг Төв банк дээр авах хүсэл гаргасан. Монголын нийт гадаад валютын гүйлгээг тогтвортой байдал дээр анхаарал хандуулах боломж байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН АНХДУГААР ЧУУЛГАН:

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН СОРИЛТ, ЧИГ ХАНДЛАГА

ХУРЛЫН ТОВЧООН: 2018 оны 1 дүгээр сарын 19-20-ны өдөр

Манай улсын эдийн засаг, макро бодлогод тулгамдаж буй сорилт, асуудлуудад шийдэл хайх, бодлогын боломжит хувилбаруудыг судалж хэлэлцдэг эдийн засгийн бодлогын чуулганыг жил бүр уламжлал болгон 2018 оноос эхлэн зохион байгуулахаар Монголбанк шийдвэрлэсэн. Энэхүү эдийн засгийн чуулган нь тухайн цаг үед болон ойрын ирээдүйд эдийн засагт тулгамдаж буй сорилт, асуудлуудыг хамтран хэлэлцэж, зөвлөмж гаргадаг жишгийг тогтоох зорилготой юм. Эдийн засгийн бодлогын анхдугаар чуулганыг “Эдийн засгийн чиг хандлага, сорилтууд” гэсэн ерөнхий сэдвийн хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК болон “УБТЗ” ХНН-тэй хамтран зохион байгуулж байна.

Монголбанкны тухай

Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагыг Монгол Улсын Төв Банк гэнэ. Монгол Улсын Төв Банкныг Монголбанк гэж нэрлэнэ. Монголбанкны төв нь Монгол Улсын нийслэлд байрлана. Монголбанк нь төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд бөгөөд тогтоосон загвараар хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино. Монголбанк өөрийн үндсэн зорилтын хүрээнд санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар үндэсний эдийн засгийн тэнцвэртэй хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

“Эрдэнэт үйлдвэр” ХХК-ны тухай

“Эрдэнэт үйлдвэр” ХХК нь зэс, молибдений хvdрийн олборлолт, баяжуулалтаар Ази тивдээ томоохонд тооцогддог үйлдвэр юм. 1978 онд хоёр орны засгийн газар хоорондын гэрээний дагуу “Эрдэнэтийн овоо”-ны орд газарт байгуулагдсан. Жилд 26 сая тонн хvdэр боловсруулж 530.0 орчим мянган тонн зэсийн баяжмал, 4.5 орчим мянган тонн молибдены баяжмал үйлдвэрлэдэг. “Эрдэнэт” үйлдвэрийн эрхэм зорилго бол эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх олон улсын хэмжээний уул уурхай, металлургийн цогцолбор үйлдвэр байгуулан хувь нийлүүлэгч хоёр орны эдийн засаг, нийгмийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулах явдал юм.

“УБТЗ” ХНН тухай

Өнөөгийн Монгол-Оросын хувь нийлүүлсэн “УБТЗ” нийгэмлэг нь 80 гаруй өртөө зөрлөг бүхий 1815 км урт төмөр замтай, 15 560 ажиллагсадтай. ОХУ болон БНХАУ-ыг холбосон гол төмөр замын нийт урт 1110 км. Суурь хүчин чадал нь жилд 22-23 сая тонн ачаа тээвэрлэнэ. Сүүлийн жилүүдэд Монгол улсад уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаатай холбогдуулан төмөр замын тээх, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх шаардлага тавигдаж байна. Төмөр замаар тээвэрлэгдэх ачааны өсөлт сүүлийн жилүүдэд 9-13% өссөн байна. 2012 онд ачааны хэмжээ 20.4 сая тн, зорчигч тээвэр 4.0 сая зорчигч тээвэрлэсэн үзүүлэлттэй байна.



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК

